

Огноо 2023.06.07

№ 23/01/06

Улаанбаатар

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4-р сарын 28-ний өдрийн 11 цагт УБ хот, СБД, Бага тойруу, Пума Импераил зочид буудлын хурлын бага танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 3-р сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах тухай
 4. ТУЗ-н гишүүд сонгож, томилох
 5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 6. Бусад
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2023 оны 3-р сарын 09-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2023 оны 3-р сарын 27-нд уг зарыг давтан, 2023 оны 3-р сарын 14-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04-р сарын 28-ний өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2023 оны 3-р сарын 29 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Д.Машбат/-д даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Д. Машбат, гишүүнээр А.Амирлан Тооллогын комиссийн даргаар С.Бат-Эрдэнэ, гишүүнээр О. Анар нарыг тус тус томилсугай.
10. “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН ДИРЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.МАШБАТ